

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын банкны салбарын зээлийн үлдэгдэл 2023 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 54.3 их наяд төгрөг байна. Зээлийн мэдээллийн тухай хууль батлагдах жилд буюу 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар банкны салбарын зээлийн үлдэгдэл 9.4 их наяд төгрөг байсан. Чанаргүй зээлийн үлдэгдэл нийт зээлийн үлдэгдлийн 10 хувьтай тэнцэж буюу зохих түвшинд байгаа бөгөөд цаашид хадгалах, бууруулах чиглэлээр банк, санхүүгийн салбарт мөрдөх хууль, тогтоомжийг нийгэм, эдийн засаг, салбарын хөгжилтэй уялдуулж батлах, шинэчлэх үйл ажиллагааг тогтмол хийж салбарын тогтвортой байдал хангагдана. Банк, санхүүгийн салбарт оролцогч талууд болох эрх бүхий байгууллагууд, зээлдэгч, зээлдүүлэгч болон бусад оролцогчдын үйл ажиллагааг тогтмол сайжруулж, эрсдэлийн удирдлагад суурилсан судалгааг үндэслэн шинэчилж хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Зээлийн мэдээллийн санд 13 арилжааны банк, 436 банк бус санхүүгийн байгууллага, харилцаа холбооны компаниуд, төрийн яам, агентлагуудын дэргэдэх сангууд, хадгаламж зээлийн хоршоо гэх мэтчилэн төрийн, хувийн хэвшлийн байгууллагууд иргэн, аж ахуй нэгжийн зээл, төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг нийлүүлдэг бөгөөд 2024 оны 2 дугаар сарын байдлаар 1.6 сая иргэн, 19.6 мянган аж ахуйн нэгжийн зээлийн мэдээлэл хадгалагдаж байна.

Зээлийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх хамгийн гол арга нь зээлийг анх олгохдоо хийх судалгаа, шинжилгээний чанарыг сайжруулж, судалгаанд шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг цаг тухайд нь олж, зөв үнэлэх явдал юм. Иймээс зээлдэгчийн зээлийн түүхийн мэдээлэл үнэн зөв байж, зээлийн үнэлгээ, зэрэглэл тогтооход шаардагдах бүх мэдээллийг бүрэн хэмжээгээр агуулсан, мэдээлэл тогтмол шинэчлэгдэж, цаг үеийн мэдээллээр баяжигдаж түүн дээр суурилсан зээлдэгчийн үнэлгээ, зэрэглэл тогтоох аргачлалыг баталсан нэгдсэн журам эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллага болох Монголбанк батлах шаардлагатай. Зээлийн мэдээллийн тухай хуулиар зээлийн мэдээллийг үйлчилгээ үзүүлэх этгээдийн эрхлэх үйл ажиллагаанд зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох гэж заасан боловч хэрхэн, ямар аргачлалаар зэрэглэл тогтоох талаар тусгаагүй, зохицуулалтгүй байна. Эрх бүхий байгууллагаар нэгдсэн аргачлал, түүний баталсан журамтай болсноор зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдэж байгаа мэдээллийг зөв ашиглах, бодит байдалтай нийцсэн, нэгдсэн аргачлалаар зээлдэгчийн зэрэглэлийг тогтоох боломжтой болно.

Зээлдэгчийн зээлжих чадварыг нэгдсэн аргачлалаар тодорхойлсноор зээлийн эргэн төлөлтийн найдвартай байдлыг хангах, банк, санхүүгийн салбарын тогтвортой ажиллагаа, аюулгүй байдал, банкны системийн нийт 28.6 их наяд төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл хөрөнгийн эргэн төлөгдөх баталгаа хамаарч байна.

Зээлдэгчийн хувийн болон өмнөх зээлийн үүрэгтэй холбоотой бодит мэдээлэл нь зээлдүүлэгчийн гаргах зээлийн шийдвэр, зээл эргэн төлөгдөх найдвартай баталгааг хангаж байх учиртай. Энэ хугацаанд зээлийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийг нь баяжуулах чиглэлээр Монголбанкнаас арга хэмжээ авч хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд ялангуяа программ хангамж, техник тоног төхөөрөмжийг сайжруулах тодорхой төслүүдийг хэрэгжүүлж ирсэн. Зээлийн мэдээллийн тухай хуульд зээлийн мэдээллийг үйлчилгээ үзүүлэх этгээд зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох гэж заасан боловч ямар аргачлал, журмын дагуу үнэлгээ хийж, зэрэглэл тогтоох талаар хуульд заагаагүй бөгөөд зээлдэгчийн зээлийн мэдээллийг зөв, бодит байдалтай нийцүүлэн ашигласнаар банк, санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын санхүүгийн сахилгыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлж шийдвэр гаргалтыг тоон мэдээлэл, тодорхой арга, аргачлалыг үндэслэн хэрэгжүүлэх боломжтой болно.

Тиймээс Зээлийн мэдээллийн тухай хуулийн зохицуулалтыг илүү боловсронгуй, зохицуулалтгүй харилцааг тодорхой болгох замаар зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох аргачлалыг батлах эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаар батлуулах нь банк, санхүүгийн салбарын дунд, урт хугацааны хөгжлийг дэмжих нөхцөл бүрдүүлэх юм.

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 онд 69.0 их наяд төгрөг хүрсний гол шалтгаан нь уул уурхайн салбарын өсөлт тухайлбал нүүрсний экспортын өсөлттэй шууд холбоотой. Цаашид энэхүү өсөлтийг дунд, урт хугацаандаа тогтвортой хадгалахад гадаадын шууд хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон банк, санхүүгийн салбарын зээлийн үйл ажиллагааны дэвшил, түүн дотор оролцогч талуудын мэдээллийн ил тод байдал, үнэн зөв мэдээлэлд суурилсан зээлийн санхүүжилттэй холбоотой юм.

Үйл ажиллагааны цар хүрээ, орлого, ажлын байраар иргэдийг хангах, татвар төлөлт зэрэг үзүүлэлтээс харвал дотоодын аж ахуйн нэгжүүд нь банк, санхүүгийн салбарын томоохон оролцогчдын нэг болсныг илтгэх бөгөөд үүний үр дүнд дотоодын нийт бүтээгдэхүүнд өөрчлөлтөд үзүүлэх нөлөө нэмэгдэж эдийн засгийн өсөлт, хүртээмжийн асуудал банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаатай нягт холбоотой болсон. Банк, санхүүгийн салбарын хүртээмжийн асуудлыг тогтмол сайжруулж, тоон мэдээлэл, нэгдсэн арга, аргачлалаар хангах нөхцөлийг хууль, эрх зүйн өөрчлөлтөөр бий болгосноор нийгэм, эдийн засгийн өсөлт, хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо:

Он	2019	2020	2021	2022	2023
Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо (мянга)	75.5	76.3	81.5	91.8	96.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлогын нэг хэрэгсэл бол зээл, санхүүжилтийн үйлчилгээг эрсдэлийн удирдлагад суурилж нэвтрүүлэх бөгөөд үр дүнг нэгдсэн зэрэглэл тогтоох аргачлалаар үнэлэх явдал юм. Тэгснээр зээлийн мэдээллийг ашиглаж аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай уялдсан санхүүгийн үйлчилгээг бий болгоно.

Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж дундаж давхаргыг бэхжүүлсэн нийгэм, эдийн засгийн орчныг бий болгож дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн өрх, гэр бүлд хүртээмжтэй банк, санхүүгийн үйлчилгээ бүтээгдэхүүнээр ханган, эрсдэлээс хамгаалах бодлого хэрэгжиж, өрх, гэр бүл өөрийгөө тэтгэн амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилт дэвжүүлсэн. Монгол Улсын хүн амын тоо 2035 онд 4.02 сая хүрэх төсөөлөлтэй байгаа бол насны бүлгээр ангилбал өсөлтүүд голцуу зээлийн харилцаанд орох насны бүлэгт хамаарч байгаа тул цаашид банк, санхүүгийн үйл ажиллагаа цахим руу шилжих, их өгөгдөл буюу зээлдэгчийн зээлийн мэдээлэл дээр суурилсан шийдвэрийг гаргах шаардлагатайг илтгэж байна.

Хүн амын тоо насны бүлгээр:

Насны бүлэг	2020	2035	Өөрчлөлт
85+	9,596	13,328	39%
80-74	14,143	24,784	75%
75-79	24,683	59,338	140%
70-74	34,515	100,918	192%
65-69	56,726	133,221	135%
60-64	100,790	169,495	68%
55-59	141,592	199,831	41%
50-54	164,767	231,542	41%
45-49	193,511	280,309	45%
40-44	216,911	248,166	14%
35-39	243,496	221,176	-9%
30-34	289,242	213,196	-26%
25-29	253,176	282,154	11%
20-24	224,202	373,699	67%
15-19	215,334	380,491	77%
10-14	284,193	366,018	29%
5-9	375,591	352,035	-6%
0-4	382,684	375,437	-2%
Нийт	3,227,172	4,027,173	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын насжилт уртсаж улмаар хөдөлмөр эрхлэх иргэдийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд банк, санхүүгийн салбарын үйл ажиллагааг зээлдэгчийн зээлийн мэдээлэл дээр суурилсан үнэлгээ, зэрэглэл тогтоох аргачлалыг баталж хэрэгжүүлснээр банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаа тухайн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдаж санхүүжилтийн хүртээмж, салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Төсвийн орлого нэмэгдэж төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн бөгөөд ажиллах хүчний дотооддоо өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр аж ахуйн нэгжүүд мэргэжлийн, ур чадвартай ажиллах хүчнийг өрсөлдөхүйц цалин, урамшууллаар татах тогтолцоо бий болсон. Харамсалтай нь нэг өрхийн дундаж орлого бусад нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүдтэй уялдаж нэмэгдэхгүй байгаа нь өрхийн хуримтлал бага, зээлийн санхүүжилтээр хэрэглэлээ тэтгэх, өрхийн

орлого, зардалд суурилсан банк, санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүний хүртээмжийн асуудалтай холбоотой юм. Тиймээс өрхийн орлого, зардалд суурилсан санхүүгийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

Өрхийн сарын дундаж орлого:

Он	2019	2020	2021	2022	2023
Нэг өрхийн сарын дундаж орлого (төгрөг)	1,375,080	1,424,598	1,642,915	1,846,967	2,286,259

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгэм, эдийн засгийн харилцаа улам өргөжиж түүнээс бий болж байгаа их өгөгдөл, тоон мэдээллийг нэгдсэн системд оруулж хадгалах чиглэлээр олон ажлууд хийгдэж байгаагийн нэг жишээ бол e-mongolia юм. Зээлдэгчийн зээлийн мэдээллийг санд төвлөрүүлэх нарийвчилсан зохицуулалт байгаа ч зээлдэгчийн зээлийн мэдээллийг ашиглаж зээлдэгчийн зээлжих чадварт үнэлгээ хийх аргачлалыг эрх бүхий байгууллагаар батлуулах зохицуулалт байхгүй байна. Эдийн засгийн өсөлт, хүн амын насны бүтэц, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны цар хүрээнд нийцсэн банк, санхүүгийн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг их өгөгдөл, тоон мэдээлэл болон зээлийн мэдээллийн санд хадалдагдаж буй зээлдэгчийн зээлийн мэдээлэлд үндэслэж гаргах учиртай. Зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох асуудлыг эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаас баталж нэгдсэн арга, аргачлалтай болсноор үнэлгээнд суурилсан банк, санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлэх боломж бүрдэж салбарын өсөлтийг хадгалах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно.

Банкны салбарын нийт актив хөрөнгийн хэмжээ 2024 оны 1 дүгээр сарын байдлаар 54.2 их наяд төгрөгт хүрсэн бол мөн хугацаанд арилжааны банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 5.8 их наяд төгрөг болж нэмэгдсэн байна. Арилжааны банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 0.7 их наяд төгрөг байсан бол банкны салбарын үйл ажиллагаа өргөжиж, ашигт ажиллагаа нэмэгдэн нээлттэй компанийн хэлбэрт шилжсэнээр өөрийн хөрөнгө 8.3 дахин нэмэгдсэн байна.

Аж ахуйн нэгж, иргэдийн зээлийн үлдэгдлийн өөрчлөлтүүдийг авч үзвэл мөнгөний бодлого, эдийн засгийн төлөв байдлаас хамааран иргэдийн зээлийн үлдэгдлийн өсөлт аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлээс өндөр байх үеийг сүүлийн банк, санхүүгийн салбарын тоон үзүүлэлтүүдээс харах боломжтой бөгөөд энэ нь зээл, санхүүжилт олгох байгууллагын хүлээн зөвшөөрч болох эрсдэлийн түшинтэй хамааралтай юм. Эдийн засгийн тэлэлт явагддаг үед банк, санхүүгийн байгууллагууд хүлээн зөвшөөрч болох эрсдэлийнхээ хүрээнд аж ахуйн нэгжид олгох зээл нэмэгдүүлдэг тул сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагын зээл, санхүүжилтийн үйл ажиллагаа өргөжсөн байна.

Зээл, санхүүжилт, санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын зээлийн үлдэгдлийн хэмжээ 2023 оны байдлаар:

Зээлдүүлэгч байгууллага	Зээлийн үлдэгдэл /сая төгрөг/
Банк	27,151,616.66
Банк бус санхүүгийн байгууллага	3,675,862.20
Хадгаламж зээлийн хоршоо	204,238.30

Эх сурвалж: Монголбанк

Төрөөс хадгаламжийн даатгалын хууль баталж, банкин дахь иргэд, байгууллагын хадгаламжийг 100 хувь хариуцахаар баталгаа гаргасан нь банкнуудын зээлийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ байсан боловч илүү эх өгөгдөл, мэдээллийн технологийн хөгжил, дэвшилд суурилсан тогтолцоогоор хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний нэг жишээ бол зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй зээлдэгчийн зээлийн мэдээллийг нэгтгэн, үнэлгэх, зэрэглэл тогтоож эрсдэлийн үнэлгээнд суурилсан зээлийн бүтээгдэхүүнийг бий болгож зээлийн эргэн төлөлтийн найдвартай байдлыг хангаснаар хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг эрсдэлгүй байлгах боломжийг бүрдүүлсэн.

Олон улсад хадгаламжийн даатгалын байгууллагаас гадна зээл, санхүүжилтийн үйл ажиллагааг хянах, оролцогч талуудын эрх, ашгийг хангуулах бодлогын байгууллагууд байдаг. Энэхүү байгууллагуудын чиг үүрэгт тухайн улсын хууль, тогтоомжид нийцүүлсэн өөрсдийн гэсэн зээлжих зэрэглэл тогтоох бодлого хэрэгжүүлэн ажилладаг байна.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох аргачлалыг батлах төрийн агентлагууд:

Улс	Байгууллагын нэр	Өмчийн хэлбэр
АНУ	Consumer Financial Protection Bureau (CFPB), Federal Trade Commission (FTC)	Төрийн өмч
Их британи	The Financial Conduct Authority (FCA)	Төрийн өмч
Канад	Financial Consumer Agency of Canada	Төрийн өмч
Австралиа	Australian Securities and Investments Commission	Төрийн өмч
Герман	Federal Financial Supervisory Authority	Төрийн өмч
Энэтхэг	Credit Information Bureau	Төрийн өмч
Япон	Financial Services Agency	Төрийн өмч

Эх сурвалж: Дээрх төрийн агентлагуудын цахим хуудас

Олон улсын жишгээр бодлого тодорхойлогч байгууллагууд нь зээлдэгчийн зэрэглэл тогтоох бодлого, аргачлал баталж, хэрэгжилтийг хянадаг буюу нэгдсэн бодлогоор зээлийн эргэн төлөлтийн байдал, зээл эрсдэлд орсон шалтгаан болон бусад зээлдэгчийн онцлогоос хамааран хэрхэн зээлдэгчийн үнэлгээг тогтоох аргачлал баталдаг байна.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсанаар банк, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ, удирдлагад суурилсан үйл ажиллагаа сайжирч, зээл, санхүүжилт нэмэгдэх нөхцөл бүрдүүлнэ. Нэг талаас зээлдүүлэгч эрсдэлгүй, зөв шийдвэрийг шуурхай гаргах боломжтой

болж, хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ буурах ба нөгөө талаас зээлдэгч өөрийн зээлийн түүхийг хянан удирдаж, санхүүгийн менежментээ зөв хийж эхлэх ба санхүүгийн сахилга хариуцлага сайжрах юм. Зээлдэгчийн зээлийн түүхийн мэдээлэл боловсронгуй болсноор Монгол Улсын бүртгэл мэдээллийн тогтолцоонд ахиц, дэвшил гарна. Хөгжингүй орнуудад ажиллаж байгаа мэдээллийг нэг дороос авах нэгдсэн сан Монгол Улсад цогцоор нь бий болж хөгжүүлэхэд энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлт ихээхэн үүрэг гүйцэтгэх болно. Зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох аргачлалыг Монголбанк баталж зээлдэгчийн мэдээллийн зээлийн лавлагаанд тусгах хугацааг зургаа хүртэлх жил болгосноор дараах ач холбогдолтой:

- Зээлийн мэдээллийг ашиглан зээлдэгчийн зээлжих зэрэглэл тогтоох нэгдсэн аргачлал, журамтай болно;
- Зээлийн эрсдэлийг удирдах нэгдсэн систем, бүтэц бий болно;
- Их өгөгдөл буюу зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийг ашиглан зээлжих зэрэглэлд хамаарах банк, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой;
- Банк, санхүүгийн салбарын оролцогч талуудын санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд зургаан жил тусгах гэсэн заалтыг зургаа хүртэлх жил болгох зохицуулалтаар банк, санхүүгийн салбарын хөгжил, нийгэм, эдийн засагт гарж буй өөрчлөлтүүдтэй уялдуулан зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах боломжтой болно. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлжих зэрэглэл тогтооход ашиглах, зээлдэгчийн зээлжих зэрэглэл тогтоох аргачлалыг эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаар батлуулснаар банк, санхүүгийн салбарын хүртээмж буюу эрсдэлийн үнэлгээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн.